



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/598

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сумдын цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангах” сэдэвт сургалтыг зохион байгуулахад 3,280,000.00 (гурван сая дөрвөн зуун арван таван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 05 -ний өдрийн
А/С.З. дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Завсарлагааны цайны багц	Ш	45	12,000	540,000.00
2	Ус (0,5 л)	Ш	45	1,000	41,000.00
3	Өдрийн хоол	Ш	45	37,000	1,665,000.00
4	Түлш	л	200	2,900	580,000.00
5	Томилолт	хоног	5	90,000	450,000.00
	Нийт				3,280,000.00